



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/295

Мандалговь

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн
комиссыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.1, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 23-ны А/400 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 1.5, 1.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс”-ыг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн баталсугай.

Комиссын дарга:

Гишүүд:

Эрүүл мэндийн газрын дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн эрүүл мэндийн асуудал

хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын салбарын гүйцэтгэх захирал (зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:

Эрүүл мэндийн газрын эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, тусгай зөвшөөрөл, ёс зүй хариуцсан мэргэжилтэн

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журмыг мөрдлөг болгон удирдлага зохион байгуулалтаар ханган хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг комиссын даргад үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн А/229 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



4822111036